



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 636

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын сангийн дүрэм,
хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт
нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, 55 дугаар зүйлийн 55.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сод аллокэйшн хувийн ХОС” ХХК-ийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт хавсралтад заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын таван өдрийн дотор мэдэгдэхийг “Сод ассет менежмент ҮЦК” ХХК (С.Даваасамбуу)-д үүрэг болгосугай.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Сод ассет менежмент ҮЦК” ХХК (С.Даваасамбуу)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



1518001362

Санхүүгийн зохицуулах хорооны 2022
оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн
636 дугаар тогтоолын хавсралт



Хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд
оруулах нэмэлт, өөрчлөлт

5.7' Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгасан тохиолдолд Компани дараах байдлаар багц бүрдүүлэх болно. Үүнд:

- 5.7.1' Хувьцаа 1-70 хүртэл хувиар;
- 5.7.2' Өрийн хэрэгсэл 25-95 хүртэл хувиар;
- 5.7.3' Мөнгөн хөрөнгө 0.01-5 хүртэл хувиар;

Хөрөнгө оруулалтын бодлогын
баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлт

4.1.7. Макро эдийн засгийн орчинд өөрчлөлт орж, Монгол Улсын инфляци эсвэл бодлогын хүү хоёр оронтой тоонд хүрсэн тохиолдолд 4.1.5-д заасан ердийн нөхцөл өөрчлөгдөн ердийн бус нөхцөл байдал үүссэн гэж үзнэ. Ердийн бус нөхцөл байдал үүссэн тохиолдолд сангийн хөрөнгийн багцад бондын эзлэх хувь хэмжээг 95 хувь хүртэл нэмэгдүүлж болно.

4.1.8. Энэхүү баримт бичгийн 4.1.7 дахь заалтыг хэрэгжүүлсэн нөхцөлд сангийн хөрөнгийг дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулахыг зорилт болгоно.

| Хөрөнгийн төрөл | | Багцад эзлэх хувь (зорилтот) |
|-----------------|--|------------------------------|
| Хувьцаа | Дотоодын нээлттэй болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа | 1-70% |
| | Гадаадын нээлттэй компанийн хувьцаа | 1-70% |
| | | 0-10% |
| Бонд | Хөрөнгө оруулалтын зэрэглэлийн бонд | 25-95% |
| | Хөрөнгө оруулалтын зэрэглэлээс доогуур зэрэглэлийн бонд | 0-10% |
| | | 20-95% |
| Мөнгө | | 0.01-5% |